



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/30

Улаан-Уул

Өвөл хаврын хурдан морины уралдаан
зохион байгуулахыг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр сарын 9.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2019 оны А/79 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Унаач хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор жил бүрийн 11 дүгээр сарын 05 –наас 05 дугаар сарын 01-нийг хүртэл хугацаанд өвөл хаврын хурдан морины уралдааныг (үсэргээ, сунгаа) сумын нутаг дэвсгэрт зохион байгуулахыг хориглосугай.

2. Өвөл хаврын байгаль цаг агаарын таагүй нөхцөлд морины уралдааны үед гарч болзошгүй сөрөг нөлөө, үр дагаврыг олон нийтэд ухуулан таниулж ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Хүрэлбаатар), Ерөнхий боловсролыг сургуулийн захирал (Ө.Хашбилэг), сумын Уяачдын холбооны тэргүүлэгчдэд даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг багуудын Засаг дарга нарт, зөрчлийг шуурхай таслан зогсоох, хариуцлага оногдуулахыг Цагдаагийн хэсгийн төлөөлөгч (Д.Насанжаргал)-д тус тус үүрэг болгосугай.



ДАРГА Т.ЭРДЭНЭБАТ

642201027